



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Уламжлалт анагаах ухаан
рашаан сувиллын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/21/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дорноговь аймаг 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Ахлах аудитор: Э.Энхцэцэг Цахим хаяг: enkhtsetsege@audit.gov.mn Аудитор: Б.Ариунбаатар Цахим хаяг: ariunbaatarb@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

дод. 02.24 № 1-8/125

танай _____ -ны № _____ -т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН УЛАМЖЛАЛТ
АНАГААХ УХААН РАШААН СУВИЛЛЫН
ТӨВИЙН ДАРГА П.ЭРДЭНЭЦЭЦЭГ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Уламжлалт анагаах ухаан рашаан сувиллын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Уламжлалт анагаах ухаан рашаан сувиллын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.ГАН-ӨЛЗИЙ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	59.9	66.9
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	654.9	627.3
	Нийт хөрөнгийн дүн	714.8	694.2
	Нийт өр төлбөрийн дүн	0.0	10.9
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	714.8	683.3
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	714.8	694.2
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	495.5	498.6
	Үйл ажиллагааны зардлын дүн	484.0	529.7
	Үйл ажиллагааны үр дүн	11.5	-31.2
	Үйл ажиллагааны бус үр дүн	0.0	-0.3
	Үйл ажиллагааны нийт үр дүн	11.5	-31.5
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	714.9	714.9
	Тайлант оны үр дүн		-31.5
	Эцсийн үлдэгдэл	714.9	683.3
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	459.0	481.0
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	453.6	479.6
	Үйл ажиллагааны ЦМГ	5.4	1.3
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-5.4	-1.3
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	0.0	0.0
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0.0	0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	0.0	453.0
	Урсгал зардал	0.0	453.0
	Хөрөнгийн зардал	0.0	
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	0.0	453.0
	Улсын төсвөөс санхүүжих	0.0	35.0
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	0.0	40.0
	Нийгмийн даатгалын төсвөөс санхүүжих	0.0	378.0

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дорноговь аймгийн УАУРСТ-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна.

- Уламжлалт анагаах ухаан рашаан сувиллын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд уламжлалт анагаах ухаан, чанар нөөц нь тогтоогдсон рашаан ус, байгалийн нөөцийг ашиглаж ээрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудын мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, эмчлэх, сэргээн засах, сувилах тусламж үйлчилгээг цогцоор нь хөгжүүлэх.

Эрхэм зорилго: Уламжлалт анагаах ухаан байгалийн нөөцөд тулгуурлан орчин цагийн анагаахын дэвшилтэт технологитой хослуулан эмчилгээний төрөл, хүртээмжийг өргөжүүлж, үйлчлүүлэгчдийн сэтгэлд нийцсэн эмчилгээ үйлчилгээг нэвтрүүлэх.

Алсын хараа: Байгалийн нөөц, рашаан ус, өрнө, дорнын анагаах ухааны зүй зохистой хослуулан эмчлэх, нөхөн сэргээх, сувилах асрах тусламж үйлчилгээг цогцоор нь хөгжүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

Ковид-19 цар тахал өвчинтэй холбоотой засгийн газрын тогтоол, шийдвэрүүд шинээр гарч хэрэгжсэн.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

ЭМЯ-ны 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 4/422 тоот албан бичгийн дагуу эрүүл мэндийн салбарт санхүүжилтийн шинэчлэлийг хэрэгжүүлж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь 2021 оноос эхлэн гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг авч эхэлсэн байна.

2022 онд Халзан-Уул рашаан сувилал нь тус байгууллагад нэгдэн үйл ажиллагаа явуулах шийдвэр гарсан байна.

Дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллийг хугацаандаа оруулсан, хугацаа хоцроож мэдээлсэн мэдээлэл байхгүй байна.

Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын гүйлгээг бүрэн оруулсан ба зарлагын нийт 40.5 сая төгрөгийн 7 ажил гүйлгээнээс 1 ажил гүйлгээг байршуулан 34.9 сая төгрөгийн 6 ажил гүйлгээний зардлыг байршуулаагүй байна. Хөрөнгө зарцуулах 29.4 сая төгрөгийн 25 тушаал, шийдвэр гарсан. Үүнээс 150.0 мянган төгрөгийн 3 тушаал хугацаа хоцроож байршуулсан байна.

Тав. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

Зургаа. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 6.1 сая төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс, 6.1 сая төгрөгийн 4 алдааг залруулж, 1 зөвлөмж, 1 албан шаардлага өгсөн.

Залруулсан алдаа:

1. Тайлант оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангаар ажилчдаас авах авлагыг өглөгийн дансанд /-/ тэмдэгтэйгээр тусгасныг залруулав.

2. Тус байгууллага нь тайлант онд цалингаас бусад зардлыг гүйцэтгэлээр санхүүжүүлсэн ба зардлыг 210902 зардлын ангиллаас зарцуулсан байна. Үүнтэй холбоотойгоор санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлууд холбогдох эдийн засгийн ангиллын дагуу бүртгэгдээгүй ба бичиг хэргийн зардлыг бусдаар гүйцэтгүүлсэн ажлын зардалд тусгасан, БҮТЭЗ-ын зардлыг хог хаягдлын зардалд, шуудан холбооны зардлыг мэдээлэл технологийн үйлчилгээний зардалд бүртгээснийг залруулав.

3. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн холбогдох зардлуудыг эдийн засгийн ангиллын дагуу тайлагнаагүй байна.

4. Үндсэн хөрөнгийн элэгдлийг 20.3 мянган төгрөгөөр илүү бодуулсныг залруулав.

Албан шаардлага:

Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын гүйлгээг бүрэн оруулсан ба зарлагын нийт 40.5 сая төгрөгийн 7 ажил гүйлгээнээс 1 ажил гүйлгээг байршуулан 34.9 сая төгрөгийн 6 ажил гүйлгээний зардлыг байршуулаагүй байна. Хөрөнгө зарцуулах 29.4 сая төгрөгийн 25 тушаал, шийдвэр гарсан. Үүнээс 150.0 мянган төгрөгийн 3 тушаал хугацаа хоцроож байршуулсан байна.

Мэдээллийг нөхөн байршуулах, хугацаандаа байршуулах, цаашид хугацаа хоцроох, мэдээллийг байршуулахгүй байх зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

Зөвлөмж:

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Ажил гүйлгээний ангитай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант онд байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 67.1 сая төгрөгийн 83 нэр төрлийн 144 хөрөнгө бүртгэлтэй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг актлах, эсхүл дахин шинээр үнэлгээ тогтоон цаашид ашиглах асуудлыг шийдвэрлэх.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Уламжлалт анагаах ухаан рашаан сувиллын төв	1	1	-	-	1	-	-	-
	НИЙТ	1	1			1			

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	Уламжлалт анагаах ухаан рашаан сувиллын төв	6	6.1	4	6.1	-	-	1	-	1	-
	НИЙТ	6	6.1	4	6.1	-	-	1	-	1	-